

ХУДАГТЫН АМНЫ ХҮН ЧУЛУУН ХӨШӨӨ

Б.ДАВААЦЭРЭН¹, Г.АНХСАНАА²

¹ССАЖ Яамны харъяа Соёлийн өвийн төв, e-mail: davaatserenb2000@yahoo.com

²ССАЖ Яамны харъяа Соёлийн өвийн төв, e-mail: g.anhaa@yahoo.com

Түлхүүр үг: Дорнод Монгол, хүн чулуун хөшөө, Эртний Түрэг, ашина, янгир, тамга

ТОВЧ АГУУЛГА: Энэхүү тэмдэглэлд Хэнтий аймгийн нутгаас шинээр илрүүлэн олсон нэгэн хүн чулуун хөшөөг судлаачдын сонорт хүргэхийг зорилоо. Тус хүн чулуун хөшөөн дээр эртний түрэгийн ашина овгийн тамга болох янгирын дүрс болон эр хүйсийн тэмдэг, саран тамга зэргийг сийлж үлдээсэн нь сонирхолтой юм. Уг хүн чулуун хөшөө Дорнод Монголын бүсэд оршиж байгаа нь анхаарал татах бөгөөд түүн дээр дүрсэлсэн янгир, саран тамга зэрэг нь тухайн үеийн Түрэгийн эзэмшиж байсан газар нутаг, өвөг Монгол овог аймгуудтай хийсэн дайн тулаан зэргийг тодруулан судлахад ач холбогдолтой судалгааны хэрэглэгдэхүүн болох юм.

Монгол орны нутаг дэвсгэр дээр оршиж байсан эртний хүчирхэг улс бол НТ VI зууны дунд үеэс бүрэлдэн тогтсон Түрэг улс юм. Манай улсын нутаг дэвсгэрт Түрэгүүдийн түүхэнд холбогдох олон арван түүхийн дурсгалууд хадгалагдан үлдсэн байдаг.

Энэ үеийн археологийн дурсгалуудыг судлан шинжлэх явдал XIX зууны сүүлчээс эхэлсэн бөгөөд энэ нь Монгол орны археологийн дурсгалыг шинжлэх ухааны үүднээс судлах ажлын эхлэл болсон хэмээн үздэг (БНМАУ-ын түүх., 1955: 14). Түрэг угсаатанд холбогдох археологийн эд өлгийн дурсгалт зүйлийг хаад ноёд, жирийн иргэдэд зориулсан тахил тайлгын онгон, тэдгээрийн бүрэлдэхүүнд багтах хүн чулуун хөшөө, адгуус амьтны дүрс, руни бичээст пайлуур хөшөө, уран барилгын холбогдолт дурсгал, хад чулуу болон бусад эд зүйлд сийлбэрлэн гаргасан элдэв зураг, их бага бичээсийн зүйлс, нас барагсдыг оршуулсан булш, хиргисүүр хэмээн ангилан авч үздэг байна (Баяр, 2003б: 169). Эдгээрийн дотроос Түрэгийн тахил тайлгын онгоны нэг бүрэлдэхүүн хэсэг болох хүн чулуун хөшөө нь эртний овог аймгуудын түүх, эзэмшил нутаг, нүүдэл суудал хийгээд соёл боловсрол, үйлдвэрлэхүй хүчний хөгжил, шашин шүтлэг, дадал заншил зэрэг олон талт асуудлыг сэргээн судлах үнэт сурвалж болохоос (Баяр, 1997: 5) гадна тухайн үеийн

хүмүүсийн төрх байдал, хувцас өмсгөл, эд хэрэглэл, гоёл чимэг, зэр зэвсгийн төрөл зүйл, тэдгээрийн онцлог зэргийг тодруулж судлахад онцгой ач холбогдолтойн дээр тэр үеийн дүрслэх урлагийн хөгжил, гоо сайхны үзлийн хэмжээ түвшинг илтгэн харуулдаг (Баяр, 2003б: 169, 180-181).

Бид энэхүү өгүүлэлд Хэнтий аймгийн Мөрөн сумын нутгаас илрүүлэн олсон нэгэн хүн чулуун хөшөөний тухай судлаачдад мэдээлэхийг зорив. Уг хүн чулуун хөшөө нь Хэнтий аймгийн Мөрөн сумын төвөөс баруун тийш 20 орчим км-т орших Салбар уулын баруун урд бие, Худагтын аманд оршино. Хөшөө орших газрын солбилцол N 47°19' 122", E 110° 05' 059", Alt 1331м.

2000-аад оны эхэн үеийн байдлаар Монгол улсын нутаг дэвсгэрт нийтдээ 500 гаруй хүн чулуун хөшөө олдож бүртгэгдээд байгаагийн 400 гаруйг нь Түрэгийн үед холбогдуулан үзэж (Цэвээндорж нар, 2003: 181; Монгол Улсын..., 2004: 331) байсан бол өнөөдрийн байдлаар энэ тоо 100 гаруйгаар нэмэгдэж 600-д хүрснээс 500 орчим нь Түрэгийн үед холбогдож байна (Отгон, 2011: Хавсралт 2). Түрэгийн үеийн хүн чулуун хөшөө манай орны баруун болон төвийн бүсийн нутгуудаар илүү их нягтран бөөгнөрсөн байдаг бол өмнөд, умард, дорно зүгийн нутгаар нилээд таруу байдалтай байгаа нь ажиглагддаг (Сэр-Оджав 1969: 17-26; Бямбадорж, Амартүвшин 1998: 16-24; Баяр, Эрдэнэбаатар: 1999; Баяр 1997; Төрбат нар 2009: 106-159; Баяр 2004: 82-93).

Дээрх үр дүнгээс үзвэл Монголын дорнод хэсэг болох Хэнтий, Сүхбаатар, Дорнод аймгийн нутгаас Түрэгийн үед холбогдох хүн чулуу хөшөө харьцангуй цөөн илэрч олджээ. Анх 1899 онд И.В.Палибин Дорнод Монголоор аялан явах үедээ Хэрлэн голын хөндий дэх Бичигт хэмээх газарт болхи бүдүүн хийцтэй хүн чулуун хөшөөдийг олж үзсэн тухайгаа тэмдэглэн бичсэн мэдээ бий (Баяр 2009: 197). Үүнээс хойш 1948-1949 онд Монголд түүх, археологи, угсаатаны зүйн судалгаа хийсэн К.В.Вяткина Хэнтий аймгийн Наран, Бархи Жаргалант зэрэг газруудад хүн чулуун хөшөө судлаж Түрэгийн үед холбогдохыг нь тогтоожээ (1959: 94).

Мөн археологич Н.Сэр-Оджав 1962 онд Дорнод аймагт археологийн дурсгал судлах ажлаар явахдаа Түрэгийн үед холбогдох хүн чулуун хөшөө байна хэмээн мэдээлсэн байдаг (1964: 98, 99) бол 1963 онд Чехословак улсын судлаач Л.Ийсл Хэнтий аймгийн Батширээт сумын нутаг Эгийн голын хойд бие, Живхээстэйн амны адагт 5 хүн чулууг үзэж, тайландаа оруулжээ (Jisl, Ser-od-jave 2003: 443, Obr 21).

Археологич Д.Баяр 1981 онд Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан, Дарьганга, Асгат сумдын нутгаас илрүүлэн олсон 3 хүн чулууны талаар судалгаа хийж хожим нийтлүүлсэн байна (2004: 86-88).

1990-1992 онд Дорнод Монголын нутгаар төвлөрөн ажилласан Монгол-Японы хамтарсан “Гурван гол” хээрийн шинжилгээний анги Хэнтий аймгийн Батширээт, Биндэр, Баян-Адарга, Дэлгэрхаан сумдын нутгаас Түрэгийн үед холбогдох 10 хүн чулуун хөшөө бүртгэн тэмдэглэсэн байна (Gurvan gol 1994: 5, 6-7).

Сүүлийн жилүүдэд Дорнод Монголын бүс нутагт энэ төрлийн дурсгалыг давтан болон шинээр нээн илрүүлж бүртгэн судалсаар байгаа ба (Энхбат, Даваацэрэн 2009: 82; 2010: 77, 81; Даваацэрэн нар., 2008: 78-81; A Brief Report., 2011: 155-217) эдгээрийн дотор Түрэгийн үед холбогдуулж болохоор сав суулга гартаа барьсан хүн чулуун хөшөөд ч бас цөөнгүй бий (Батсайхан 2005: 12; Даваацэрэн 2009: 13-14, гар зураг 1).

Бидний өгүүлэн буй хүн чулуун хөшөө нь эрт цагт эвдэгдсэн тахилын онгоны голд байх ба цагаан саарал өнгийн том ширхэгтэй боржин чулуугаар босоо хүний тойм дүрслэл гарган үйлдсэн байна. Хөшөөний гадаргуу бүхэлдээ өгөршин барзайж, тууш хагарсан ажээ. Толгойн орой шовгор хэлбэртэй байгаа нь малгайг дүрсэлсэн гэлтэй. Нүүрийг гонзгойдуу өргөн түүштэй, эрүүг урт дүрсэлжээ. Их биеийн хэсэгт гар дүрслээгүй бөгөөд харин дунд хэсэгт 22х22 см хэмжээтэй талбайд янгирыг хажуугаас дүрсэлсэн бөгөөд түүнээс доош эр хүйсийн тэмдэг, саран тамгыг тус тус сийлсэн байна. Хүн чулуун хөшөөний өндөр 178 см, мөр орчмоор 46 см өргөн, 16 см зузаан, бүсэлхий орчмоор 49 см өргөн, 22 см зузаантай байв (Зураг 1, 2). Энэхүү хүн чулуун хөшөөний он цагийг Монгол нутгаас илэрч олдсон хүн чулуун хөшөөдтэй харьцуулан үзвэл ерөнхий хийц байдал зэргээрээ түрэгийн үед холбогдуулан үзэж болмоор бөгөөд, түүн дээр сийлсэн янгирын дүрс зэрэг нь үүний бас нэг нотолгоо болох юм.

Өмнө нь хийгдсэн судалгаануудаас харахад Түрэгийн үеийн хүн чулуун хөшөөг үйлдэхдээ ихэвчлэн хүний биеийг бүтнээр нь, эсвэл хэсэгчлэн дүрслэх арга барил хэрэглэсэн байдаг. Бүтнээр дүрсэлсэн хүн чулуун хөшөөдийн дотор босоо болон суугаа байдлаар үйлдэх гэх мэт ялгаа байх бөгөөд хүний дүр төрхийг бодит байдалд ойртуулан чадварлагаар дүрслэхээс гадна энгийн болхи хийцтэй хүн чулуун хөшөөд ч цөөнгүй байна.

Бидний илрүүлж олсон хүн чулуун хөшөө хийцийн хувьд нилээд болхи байгаа бөгөөд Түрэгийн үеийн хүн чулуун хөшөөний талаар Д.Баярын “Монголын төв нутаг дахь түргийн хүн чулуу” хэмээх бүтээлд хийсэн ангиллаар тойм дүрслэлтэй хөшөө чулуунд хамаарах ба өмнө нь ийм хүн чулуу манай улсын нутгаас 7 олдож байжээ (1997: 28). Зарим судлаачид Монгол Алтайн бүс нутагт илэрч олдсон Түрэгийн үеийн тахилын онгоныг тухайлсан хүнд зориулсан тахилын байгууламж, нөхөд дайчид, гэр бүл болон нийтлэгт зориулсан тахилын байгууламж, овог, аймгийн болон нийтийн тахилын байгууламж хэмээн ангилах санал дэвшүүлсэн байдаг (Мөнхбаяр 2010: 108-112) бөгөөд энэ ангиллаар бол дээрх хөшөө эхнийхэд буюу тухайлсан хүнд зориулсан тахилын байгууламж гэдэгт хамаарч болох юм.

Түүнчлэн, бидний сонирхлыг татаж байгаа нэг зүйл бол тус хүн чулууны дунд хэсэгт сийлсэн янгирын тамга болно (Зураг 1). Янгирын тамгыг Хөшөө Цайдамд орших Культегины гэрэлт хөшөө, Онгийн голын дурсгал болон Хөл Асагтын тахилын онгон зэрэг Монгол нутагт орших Түрэгийн хаад язгууртанд

зориулан байгуулсан тахил тайлгын онгоны хөшөөнөө сийлсэн байдаг (Радлов, 1892, 16-17 Pic XVII). Мөн Хөшөө Цайдам III дурсгалын заримдаг дүрслэлтэй хөшөө чулуунд (76-р хүн чулуу) янгир болон дэгээ тамга, мөн орой нь хугарсан тойм дүрслэлтэй хүн чулуун хөшөөнд (78-р хүн чулуу), (Хаяаши 2005: 63, зураг 94), Батцэнгэл сумын нутаг Тоглохын талд орших бүтэн боловч тойм дүрслэлтэй хүн чулуун хөшөөнд (120-р хүн чулуу) (Баяр 1997: 84, 90-91, 97), Говьсүмбэр аймгийн нутагт орших Чойрын хүн чулуун хөшөөнд (Монгол нутаг..., 1999: 243-244) Хашаат сумын Хөшөөн дэнжийн тахилын онгоны голд босгосон хөшөө чулуунд (Даваацэрэн нар 2012) зөвхөн янгир дүрсэлсэн байдаг бол Баянхонгор аймгийн Бууцагаан сумын нутаг Гурван Мандал уул (Хойд Мандал) (Баяр 1996: зураг 6-ын 2), Хэнтий аймгийн Батширээт сумын нутагт орших Рашаанхад, Мөрөн сумын Салбар уул, Төв аймгийн Бичигт Улаан хад, Архангай аймгийн Их Тамир сумын нутагт орших Хоёр хавчиг уул (Батсүх 2004: 171, хүснэгт 1; Гантулга нар 2010: 110-111), Хотонт сумын нутаг Жарантайн голын зүүн эргээс олдсон руни бичигт хөшөө (Санжмятав 1993: 50), Дундговь аймгийн Говь-Угтаал сумын нутаг Их бичигт хэмээх газруудад түрэг, уйгур бичээсний хамт олон тамганы дотор янгирын тамга дүрсэлсэн байдаг (Баттулга 2005: 160).

Энэ талаар археологич Н.Сэр-Оджавын бичсэнээр “Янгир бол язгууртны онгон шүтээн боловч чухам ямар учраас гол тамга болж хэрэглэгдэх болсон тухай эрдэмтэд нэгдсэн саналтай болоогүй” байна гэжээ (1970: 82).

Өмнө нь олдсон янгир дүрсэлсэн хөшөө чулууны байдлаас үзвэл ихэнх нь дүрслэл багатай хөшөө чулууд болон заримдаг, тойм гэсэн ангилалд орсон хүн чулуун хөшөөнд сийлсэн байх бөгөөд тэдгээр хүн чулуудыг голчлон “бал бал” хэмээх зэл чулууны бүрэлдэхүүнд орж байгааг тэмдэглсэн байна (Баяр 1997: 28). Гэтэл зарим судлаачид Түрэгийн ноёлох овог болох ашина овог нь эхийн талаа эрхэмлэн дээдэлж үе удмаа эхээрээ тоолон тооцож өлөгчин чоныг дээдлэн, чонын толгой бүхий туг босгон дурсдаг байсан тухай эртний хятад сурвалж хийгээд археологийн хэрэглэгдэхүүн зэрэгт тулгуурлан өгүүлсэн нь сонирхолтой юм (Мэнэс 2007, 11-25).

Энэ талаар түүхч Б.Батсүрэн нэгэн сэдэвт зохиолдоо ашина ургийг Түрэгийн 12 дахь овог, аймгаар тоолсон М.Добровицийн саналыг бүрэн дэмжсэн бөгөөд ашина ургийн тамга нь янгир байдаг бол ...ашина аймгийн тамга нь адууны толгой, хүзүүг магадгүй чонын толгойг дүрсэлсэн бололтой... гэсэн түүний таамгийг тэмдэглэжээ. Мөн ашина аймгийн тамганы дүрслэлд адууны толгой, хүзүү эсвэл чоно гэхээс илүүтэй нисч буй хүчирхэг шувууг дүрсэлсэн байж болох юм хэмээн “Бүргэдээр сүлдлэх явдал монгол, дорнод слав зэрэг олон аймагт байсантай холбон үзвэл, титэмний нүүр талд байгаа бүргэд нь Куль Тегиний овгийн буюу цэргийн эрхтэнийг ялгах тэмдэг, сүлд гэж үзэхэд болмоор байна” гэсэн Н.Сэр-Оджавын саналд (1970: 139) тал өгсөн байна (Батсүрэн 2009: 96).

Энэ мэт ашина ураг болон ашина аймгийн тамга их зөрөөтэй байгаа бөгөөд ямартай ч ашина ургийн тамга болох янгир нь Түрэгийн хожуу хаант улсын үед хамаарах аж. Ашина ураг нь тухайн үед тооны хувьд хүн цөөтэй байсан хэдий ч эрх мэдлийн хувьд шийдвэр гаргагч гол тусгай давхрага болж хувирсан ба өөрөөр хэлбэл Түрэгийн хаадын язгуур гарсан ашина ургийн толгойлж байсан “төмөрчдийн хүрээ” хожим ашина ураг салж тусгай давхраа болсон хойно түүний нэрийг авч овог аймаг болсон бололтой хэмээх таамаглал байдаг (Батсүрэн 2009: 96-97).

Уг хүн чулуун хөшөөнд бидний сонирхлыг татсан удаах зүйл бол янгирын дүрсний доор эр хүйсийн тэмдэг дүрсэлсэн явдал юм (Зураг 1). Дорнод Монголын хүн чулуун хөшөөнд хийсэн судалгаа болон сүүлийн жилүүдэд Монгол нутаг дахь түүх соёлын үл хөдлөх дурсгалыг бүртгэн баримтжуулах ажлын хүрээнд зарим (Дорнод, Сүхбаатар г.м) аймгийн нутгаас эр хүйсийн тэмдэг дүрсэлсэн хүн чулуун хөшөө олдсон нь он цагийн хувьд Монголын үед холбогдохоор байгаа юм. Гэвч Түрэгийн үеийн хүн чулуун хөшөөнд эр хүйсийн тэмдэг дүрсэлсэн явдал Төв аймгийн Алтанбулаг сумын нутагт орших Өнгөтийн дурсгалын 25-р хүн чулуун хөшөөнд байгаа (Баяр 1997: 84) нь тухайн үед ийм дүрслэлийг сийлдэг байсныг харуулах баримт болно.

Үүний доор саран тамгыг мөн сийлжээ. Саран тамга нь манай улсын нутаг дэвсгэрээс нилээд түгээмэл илэрч олдсон байна. Тухайлбал: Говь-Алтай аймгийн нутаг Цагаан гол, Шивээт улаан, Мөтийн Цагаан чулуу, Бичигт улаан хад (Цагаан хороот), Хэнтий аймгийн Идэрмэг сумын Дүнгэндэг газар, Батширээт сумын Рашаан хад зэрэг газраас олдсоныг археологич Х.Пэрлээ “Монгол түмийн гарлыг тамгаар хайж судлах нь” хэмээх нэгэн сэдэвт зохиолдоо дурдсан байна. Мөн түүний зохиолд саран тамгатай холбоотой нэгэн мэдээ байна. Түүний бичсэнээр “...Нангиадын Тан улсын “Гадаад аймаг”-ийн судар шаштир гэгчид тэмдэглэн үлдээсэн адууны тамганы хэдэн дүрс юм. Энд дурдсан овог аймаг (угсаатан) нь эрт цагаас Монголын өвст хээр - хангай, говьд ихэвчлэн оршин суусан бөгөөд заримынх нь удам хожуу үед Халхчуудын удам угсааны бүрэлдэхүүнд багтаж байсан бололтой” хэмээсэн байх бөгөөд арын хүснэгтэнд Худагтын амны хүн чулуун хөшөөнд сийлсэн саран тамгатай адил тамгыг Цзе-гу (Киркут) аймгийн тамгатай адилсуулсан нь сонирхолтой байна (Пэрлээ 1976: 43, XXV хүснэгт). Цзе-гу аймаг нь хятадын түүх бичлэгт “Умардын таван аймгийн арван зургаан улсын үе” буюу хүннү гаралт Лю Юаньхай НТ 304 онд түрүү Жао улсыг байгуулснаар эхэлж, НТ 439 онд Сямьби угсааны Тобачуудын байгуулсан Умард Вэй улсыг байгуулснаар төгсдөг. Энэ аймаг нь Хятадын он дарааллын бичигт хүннү, цзеху (цзегу), сяньби, ди, цян аймгийг “таван бүдүүлэг” (Wu hu) хэмээн нэрлэгддэг аймгуудын дунд нэр дурдагдаж байгаа цзеху аймаг мөн бололтой (Дэлгэржаргал, 2005, 87).

Тиймээс дээрх хүн чулуун хөшөөнд сийлж үлдээсэн тамгыг эртний хүчирхэг Цзеху аймгийн тамга гэж үзвэл тухайн үеийн овог аймгуудын хоорондын

харилцаа холбоог илтгэх чухал баримт ч болж болох юм. Гэвч үүнийг ганц тамга төдийгөөр шийдвэрлэх нь басхүү учир дутагдалтай болохыг энд тэмдэглэе.

Зарим түүхийн бүтээлд Түрэгүүд VII зууны сүүл үед Туул голоор нутаглах огузуудын эсрэг томоохон байлдаан үүсгэж улмаар Монголын төв нутгийг (Туул, Орхон, Сэлэнгийн сав, Хангайн нурууны зүүн хэсэг) байлдан эзэлсэн мэдээ бий (Кляшторный 1964: 33-34). Мөн НТ I мянганы сүүлч хүртэл Түрэгийн тахилын цогцолборуудыг байгуулж байсан боловч зан үйлийн хувьд нилээд өөрчлөгдөж том хэмжээний тахилын цогцолборууд байгуулахаа больж, ихэнх чулуун хашлаганд зэл чулуу босгохгүй, хүн чулуун хөшөөдийг илүү том хэмжээтэй бүтээх болсон (Борисенко нар 2006: 90) зэргээс үзвэл Худагтын амны хүн чулуун хөшөө Түрэгийн хожуу хаант улсын үед холбогдох бөгөөд Түрэгийн сүр хүчийг харуулах үүднээс ашина ургийн тамгыг сийлэн үлдээсэн бололтой.

Оросын археологич В.Е.Войтовын судалснаар Монгол орны төв хэсгийн нутгаас 87 тахилын онгоны дурсгал илрээд байгаагийн баруун тал нь Идэрийн гол, зүүн тал нь Бархын голын хооронд байрладаг ажээ (1996: 3-9). Ер нь эртний овог аймгийнхны хувьд тамга нь сүлд бэлэгдэл, хамгаас эрхэм зүйл учраас дайн тулаан болсон газар ав хоморго хийсэн уул ус, онгон тахилга, хөшөө чулуу, шүтлэгт уул, бууц сууцныхаа хад чулуунаа сийлэн үлдээдэг уламжлалтай байсан бололтой. Тэгээд ч тамгаар барагцаалан аль овгийнхны нутаг, ямар овгийн хүний хөшөө дурсгал хэн хэний овгийхон ав хоморго хийсэн хийгээд яваар ирээр одсон, аль овгийнхоны нутаглаж асан нутаг зэргийг мэддэг байжээ (Баттулга 2005: 24).

Тиймээс Худагтын амны хүн чулуун хөшөө нь Дорнод Монголын бүсэд орших байрлалаараа, мөн дээр нь Түрэгийн ноёлох ашина ургийн тамга - янгир болон эртний хүчирхэг Цзеху аймгийн тамга - эр хүйсийн тэмдгийг сийлсэн байдгаараа судлаачдын анхаарал татах бөгөөд тухайн үеийн Түрэгийн эзэмшиж байсан газар нутаг, өвөг Монгол овог аймгуудтай хийсэн дайн тулаан зэргийг тодруулан судлахад ач холбогдолтой судалгааны хэрэглэгдэхүүн болох юм.

НОМ ЗҮЙ

- Батсайхан З.*, 2005. Дорнод Монголын эрт дундад үеийн нүүдэлчид // Mongolian Journal of Anthropology, Archaeology and Ethnology. The officail Journal of National University of Mongolia. Volume 1, No.1(242) May 2005, 1-14
- Батсүрэн Б.*, 2009. Өндөр тэрэгтэнүүд ба Эртний түргүүд (VI-IX зуун). Улаанбаатар
- Батсүх Д.*, 2000. Билгэ хааны тахилын онгоны балбал чулууны тамга // Studia Archaeologica, Tomus (II) XXII. Fasc.8. Улаанбаатар, 162-173
- Баттулга Ц.*, 2005. Монголын руни бичгийн бага дурсгалууд. Тэргүүн дэвтэр. Улаанбаатар
- Баяр Д.*, 1994. Монголчуудын чулуун хөрөг. Улаанбаатар
- Баяр Д.*, 1996. Гурван Мандалын хадны зураг // Studia Archaeologica, Tomus XVI. Fasc.7. Улаанбаатар, 89-102
- Баяр Д.*, 1997. Монголын төв нутаг дахь Түрэгийн хүн чулуу. Улаанбаатар
- Баяр Д.*, 2004. Түрэгийн тахилын онгоны тархацын дорнод хязгаарын тухай асуудалд. // Шинжлэх Ухааны Академийн мэдээ, №. 4, Улаанбаатар, 83-92.

- Баяр Д.*, 2007. Түрэгийн үеийн тахилын онгон, хүн чулууг судлан шинжилсэн нь. Монголын археологийн шижлэх ухаан. Боть 32. Улаанбаатар, 80-115
- Баяр Д.*, 2009. Дорнод Монголын хүн чулууг судлан шинжилсэн нь. // Eastern Mongolia and Northern Culture. 2nd International Conference. April, 2009. Ulaanbaatar State University, 197-204
- Баяр Д., Амартүвшин Ч., Энхтөр А., Гэрэлбадрах Ж.*, 2003. Билгэ хааны тахилын онгоны судалгаа // *Studia Archaeologica*, Tomus (I) XXI. Fasc.8. Улаанбаатар, 75-83
- Баяр Д., Эрдэнэбаатар Д.*, 1999. Монгол Алтайн хүн чулуун хөшөө. Улаанбаатар БНМАУ-ын түүх, 1955. Улаанбаатар
- Борисенко А.Ю., Скобелев С.Г., Худяков Ю.С.*, 2006. Төв Азийн Эртний түрэгийн соёлын судалгааны үндсэн асуудалууд // Монголын археологи, эртний түүхийн сургалтын хэрэглэгдэхүүн. Бэлтгэсэн:Ц.Төрбат, Т.Батбаяр. Улаанбаатар, 81-97
- Бямбадорж Т., Амартүвшин Ч.*, 1998. Увс аймгийн нутаг дахь түрэгийн үеийн зарим хүн чулууд. // *Studia Archaeologica*, Tomus XVIII. Fasc.10. Улаанбаатар, 116-124
- Войтов В.Е.*, 1996. Древнетюркский пантеон и модель и модель мироздания в культово-поминальных памятниках Монголии VI-VIII вв. Москва
- Вяткина К.В.*, 1959. Археологические памятники в Монгольской Народной Республике. // Советская этнография. №1, Москва
- Гантулга Ж., Ерөөл-Эрдэнэ Ч., Майгал Ж., Салисис.*, 2010. Хоёр Хавчиг уулын Түрэг бичээс // *Acta Historica*, Tomus.IX. Fasc.14. Улаанбаатар, 110-113
- Даваацэрэн Б., Эрдэнэбаатар Д., Соёл-Эрдэнэ Г.*, 2008. Дорнод Монголын нутгаас олдсон шинэ дурсгал // Улаанбаатарын их сургууль-Нийгмийн ухааны факультет. Нийгмийн шинжлэх ухааны эрдэм шинжилгээний бичиг №4 (3). Улаанбаатар, 78-81
- Даваацэрэн Б.*, 2009. Дорнод аймгийн нутаг дахь түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг бүртгэн баримтжуулсан ажлын тайлан. Соёлын өвийн Улсын нэгдсэн бүртгэл-мэдээллийн сан. Улаанбаатар
- Даваацэрэн Б., Г.Анхсанаа., Чинбат П.*, 2012. Архангай аймгийн нутаг дахь түүх соёлын үл хөдлөх дурсгалын бүртгэл, судалгааны ажлын тайлан. Соёлын өвийн төвийн бүртгэл мэдээллийн сан.
- Дэлгэржаргал П.*, 2005. Монголчуудын угсаа гарвал. Улаанбаатар.
- Монгол нутаг дахь түүх соёлын дурсгал*, 1999 (Сэдэвчилсэн лавлах). Улаанбаатар
- Монгол улсын түүх*, 2003. Тэргүүн боть. Улаанбаатар
- Мөнхбаяр Ч.*, 2010. Ховд аймгийн нутаг дахь Түргийн тахилын байгууламжийн төрөл, ангилал // Нүүдэлчдийн өв судлал. Tomus.X. Fasc.8. Улаанбаатар, 106-124
- Мэнэс Г.*, 2007. Эртний түргийн Ашина яс буюу язгуур гарсан домог ба археологийн баримт хоёрын чухам үнэн // *Studia Historica*, Tomus.XXXIX. Fasc.2. Улаанбаатар, 11-25
- Пэрлээ Х.*, 1976. Монгол түмний гарлыг тамгаар хайн судлах нь. Улаанбаатар.
- Радлов В.В.*, 1892. Атлас древностей Монголии. Санктпетербургъ, The Atlas of Historical Works in Mongolia (Selected Pages)
- Отгон Д.*, 2011. Хөшөө дурсгалын хадгалалт хамгаалалтын асуудалд (Хүн чулуун хөшөөний жишээн дээр) Магистарын зэрэг горилсон бүтээл. МУИС. Улаанбаатар сургууль. Нийгмийн ухааны факультет. Улаанбаатар
- Санжмятав Т.*, 1993. Архангай аймгийн нутаг дахь эртний түүх соёлын дурсгал. Улаанбаатар
- Сэр-Оджав Н.*, 1959. Хүл тегиний булшнаас олдсон хүн чулууны толгой // *Studia Archaeologica*, Tomus.I. Fasc 6. Улаанбаатар
- Сэр-Оджав Н.*, 1964. Археологические разведки Востойчном аймаке МНР в 1962 году. // К вопросу древнейшей истории Монголии. *Studia Archaeologica*, Tomus.III. Fasc 10. Улаанбаатар, 95-100
- Сэр-Оджав Н.*, 1969. Баян-Өлгий аймгийн археологийн дурсгалыг судалсан нь. // *Studia Historica*, Tomus.VIII. Fasc.1. Улаанбаатар, 19-266
- Сэр-Оджав Н.*, 1970. Эртний түргүүд. Улаанбаатар, 17-26

- Төрбат Ц., Баяр Д., Цэвээндорж Д., Баттулга Ц., Баярхүү Н., Идэрхангай Т., Жискара П.Х., 2009.* Монгол Алтайн археологийн дурсгалууд-I Баян-Өлгий аймаг. Улаанбаатар, 106-159
- Хаяаши Т., 2005.* Евразийн хүн чулууд. (Япон хэлээр)
- Цэвээндорж Д., Баяр Д., Цэрэндагва Я., Ц.Очирхуяг., 2003б.* Түрэгийн үеийн археологийн дурсгалууд // Монголын археологи. Улаанбаатар, 168-191
- Энхбат Г., Даваацэрэн Б., 2009.* Монгол нутаг дахь түүх, соёлын үл хөдлөх дурсгал. III дэвтэр Дорнод аймаг. Улаанбаатар
- Энхбат Г., Даваацэрэн Б., 2010.* Монгол нутаг дахь түүх, соёлын үл хөдлөх дурсгал. I дэвтэр Хэнтий аймаг. Улаанбаатар
- Энхбат Г., Даваацэрэн Б., 2011.* Монгол нутаг дахь түүх, соёлын үл хөдлөх дурсгал. II дэвтэр Сүхбаатар аймаг. Улаанбаатар
- A Brief Report for the Relationship Between Korea North Cultural and East Mongolia, 2011.* Seong Gyu, Lee. Gi Dae Bok. D.Erdenebaatar, B.Davaatseren. The Journal of Northern Cultures Studies Vol. 2 №2 / December. 2011
- Gurvan Gol. Historic Relic Probe Project. Initial Year (1991-1993), 1994.* A Report on the Joint Investigation under the Mongolian and Japanese. Mongolian Academy of Sciences and The Yomiuri Shimbun, Japan.
- Lumnr Jisl et Namsrai Ser-od-jave., 2003.* Recentes decouvertes de cravures et peintures rupestres, d' habitats, necroples et munuments turcs en la republique populaire de Mongolie // Намсрайн Сэр-Оджав. Эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэлийн эмхтгэл. Улаанбаатар, 423-455


SUMMARY

B.Davaatseren, G.Ankhsanaa

STONEMAN IN KHUDAGTIIN AM

This written article about a man stone newly discovered from territory of Khentii province was dedicated for researchers and examiners. Wild goat or the symbol of ancient Turkish tribe Ashina, male organ and half moon symbol were engraved on this stone. It is very interesting located in the eastern region of Mongolia, as well as, depictions of wild goat and half moon symbol will become important research materials for studying the territory of ancient Turkish and wars between Mongolian tribes.

ХУДАГТЫН АМНЫ ХҮН ЧУЛУУН ХӨШӨӨ



Зураг 1. Худагтын хүн чулуу



Зураг 2. Худагтын хүн чулууны гэрэл зураг